

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ 1 ДҮГЭЭР
САРЫН ӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн өсвийн 2010 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2010 оны 1 дүгээр сарын байдлаар нэгдсэн өсвийн нийт орлогын бүрдүүлэлт 111.1 хувийн биелэлттэй, нийт зарлага 74.0 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн нийт алдагдал 65.4 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 92.9 тэрбум төгрөгөөр бага байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2010 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 154.7 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 15.4 тэрбум төгрөгөөр буюу 11.1 хувиар давж биелж, 2008 оны мөн үеийнхээс 84.6 хувиар буюу 70.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:

ӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мон үеийн	жилийн Төлөв.	2010 ОНЫ 1-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв. 3	Гүйцэт. 4	(4 : 3) 5	(4 : 2) 6	(4 - 3) 7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	83.8	2,427.0	139.3	154.7	111.1	6.4	15.4
УРСГАЛ ОРЛОГО	83.7	2,403.4	139.1	140.0	100.6	5.8	0.8
ТАТВАРЫН ОРЛОГО	76.3	2,083.7	126.1	125.7	99.7	6.0	-0.4
Орлогын албан татвар	16.1	698.6	44.6	42.4	94.9	6.1	-2.3
ААН-ийн орлогын албан татвар	9.3	268.8	10.0	8.9	89.5	3.3	-1.0
Хувь хүний орлогын албан татвар	6.8	119.2	8.3	7.1	85.1	5.9	-1.2
Зарим ҮТгээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0.1	310.6	26.3	26.3	100.0	8.5	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	12.3	278.6	16.3	20.5	125.3	7.4	4.1
Өмчийн татвар	0.5	10.5	0.5	0.4	76.3	3.4	-0.1
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	33.4	696.0	44.4	37.5	84.4	5.4	-6.9
Гадаад худалдааны орлого	7.4	153.1	9.9	7.0	70.4	4.6	-2.9
Бусад татвар	6.6	246.8	10.3	18.0	175.2	7.3	7.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7.4	319.7	13.1	14.3	109.5	4.5	1.2
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.1	1.6	0.1	0.2	138.5	11.2	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.0	22.0	0.0	14.5	0.0	66.1	14.5

Монгол Улсын нэгдсэн өсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 81.2 хувь нь татварын орлогоос, 9.2 хувь нь татварын бус орлогоос, 9.4 хувь нь тусламжийн орлогоос, 0.1 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

АНУ-аас нийгмийн халамжийн зардалд зориулж 10.0 сая ам.долларын тусламж олгосон нь нэгдсэн төсвийн болон улсын төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын өсөв		Орон нутгийн өсөв		ХХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.өгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	114.1	114.5	16.3	18.0	3.1	8.8	37.3	39.0
УРСГАЛ ОРЛОГО	106.1	95.5	13.6	15.2	3.1	8.8	21.9	23.6
ТАТВАРЫН ОРЛОГО	94.1	82.1	12.5	14.3	3.1	8.8	21.9	23.6
Орлогын албан татвар	36.3	35.3	8.3	7.1	0.0	0.0	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	10.0	8.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	8.3	7.1	0.0	0.0	0.0	0.0
Зарим ҮТгээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	26.3	26.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	21.9	23.6
Өмчийн татвар	0.0	0.0	0.5	0.4	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	44.4	37.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	9.9	7.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	3.5	2.4	3.7	6.8	3.1	8.8	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12.0	13.4	1.1	0.9	0.0	0.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	8.0	19.0	2.6	2.6	0.0	0.0	15.4	15.4

- Улсын төсвийн орлого 114.5 тэрбум төгрөгт хүрч 0.4 хувиар буюу 0.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Татварын орлого 12.8 хувиар буюу 12.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн ч, татварын бус орлого 11.8 хувиар буюу 1.4 тэрбум төгрөг, тусламжийн орлого 138.7 хувиар буюу 11.0 тэрбум төгрөг өөр тус тус төлөвлөгөөнөөс давж төвлөрсөн байна.
- Орон нутгийн төсвийн орлого 18.0 тэрбум төгрөгт хүрч 10.2 хувиар буюу 1.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Сэлэнгэ аймгийн нийт орлого 0.5 тэрбум, Орхон аймгийн нийт орлого 1.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэнд тус аймгуудын ашигт малтмалын өнд ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нөлөөлсөн байна.
- Хүний хөгжлийн санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 8.8 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөнөөс 5.7 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн. Нийгмийн даатгалын сангийн орлого 39.0 тэрбум болж 4.6 хувиар буюу 1.7 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулсан. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох 15.4 тэрбум төгрөгийн татаас, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2010 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 297.6 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 177.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 220.1 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлага 74.0 хувийн, улсын төсвийн зарлага 112.1 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардал 63.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Халамжийн сангаас халамжийн тэтгэвэрт 4.5 тэрбум, жирэмсэн, амаржсан эхчүүдэд 2.0 тэрбум, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтөнд 0.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Орон нутгийн төсвийн зарлага 9.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 47.2 гүйцэтгэлтэй байна. Хүний хөгжлийн сангаас иргэдэд олгох бэлэн мөнгөнд зориулж 85.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон Нийгмийн даатгалын сангийн зарлага төлөвлөгдсөн зардалын 101.2 хувь буюу 39.2 тэрбум төгрөг байна.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны	жилийн	2010 ОНЫ 1-Р САР		ХУВЬ	ӨРҮҮ	
	мон үеийн	Төлөв.	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	
	1	2	3	4	5	6	
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112.5	2,785.6	297.6	220.1	74.0	7.9	-77.5
УРСГАЛ ЗАРДАЛ	102.4	2,172.8	258.9	207.7	80.2	9.6	-51.2
Бараа, үйлчилгээний зардал	56.1	1,055.1	95.5	66.7	69.9	6.3	-28.8
Цалин хөлс	38.8	598.9	48.9	44.3	90.5	7.4	-4.6
Нийгмийн даатгалын шимтгэл	2.9	57.3	4.7	3.1	67.3	5.5	-1.5
Бараа, үйлчилгээний бусад зардал	17.3	456.2	46.6	22.5	48.2	4.9	-24.1
Зээлийн үйлчилгээний төлбөр	0.6	42.8	1.5	1.9	132.4	4.5	0.5
Татаас ба шилжүүлэг	45.8	1,074.8	161.9	139.0	85.8	12.9	-22.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9.5	518.4	29.2	10.4	35.7	2.0	-18.8
Дотоод эх үүсвэрээр:	9.4	480.2	28.3	10.4	36.7	2.2	-17.9
Гадаад эх үүсвэрээр	0.1	38.2	0.9	0.0	5.4	0.1	-0.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	0.6	94.5	9.6	2.1	21.5	2.2	-7.5
УРСГАЛ ТЭНЦЭЛ	-18.7	230.7	-119.7	-67.7	56.5	(29.4)	52.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-28.7	-358.6	-158.4	-65.5	41.3	18.3	92.9

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 1 дүгээр сард олон улсын байгууллага, гадаадын хандивлагч орнуудаас 12.8 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 3.3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан байна. Иргэдэд олгох бэлэн мөнгөний дэвтэр хэвлүүлэхэд зориулж 875.4 сая өгрөг, гадаад паспорт хэвлүүлэхэд зориулж 240.0 сая төгрөгийн зээлийг улсын төсвөөс олгосон байна.

Төсвийн тэнцэл:

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн өсвийн урсгал тэнцэл 67.7 тэрбум төгрөг, нийт тэнцэл 65.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 4.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, нийт тэнцэл 2.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

-----oOo-----